



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/130

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Гавъяат багш Б.Даваадоржийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх зардалд 258 000 төгрөг, аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч нарт бүх сумдад ажилласан зардалд 554 300 төгрөг, Мянгад сумын Цагаан үнээтэд хээрийн сургуулилтанд гарч байгаа албан хаагч, хугацаат цэргийн албан хаагчдын хээрийн бэлтгэлийн үйл ажиллагаатай танилцсан зардал 859 000 төгрөг, Өглөө нэвтрүүлгийн Цагаан сарын шинийн нэгний дугаар бэлтгэсэн зардалд 1 711 900 төгрөг, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөрөнгө оруулагч нартай хийсэн уулзалтын зардалд 310 800 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 694 000 төгрөг /Гурван сая зургаан зуун ерөн дөрвөн мянга/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/130 Ch
02 00538